



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2017 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/349

Улаанбаатар хот

Тусгай зөвшөөрөл олгох, түтгэлзүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.21 Эрүүл мэндийн яамны “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комисс”-ын 2017 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр олгох байгууллагын нэрсийг нэгдүгээр, тусгай зөвшөөрлийн эрхийг түтгэлзүүлэх байгууллагын нэрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эм хангамжийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр болон нэмэлтээр авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Оюунчимэг/-т үүрэг болгосугай.

3. Түтгэлзүүлсэн шийдвэрийн талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд 3 хоногийн дотор мэдэгдэхийг комиссын нарийн бичгийн дарга /Д.Уранчимэг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд сайд /Л.Бямбасүрэн/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

А/349

Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 07 өдрийн  
дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



**ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР БОЛОН НЭМЭЛТЭЭР ОЛГОХ  
БАЙГУУЛЛАГЫН НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийн хугацаа
Шинээр тусгай зөвшөөрөл олгох			
1	Буяа ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
2	"ЗЖЛ" ХХК	Эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 жил
3	Шеншимин Монгол ХХК	Биологийн идэвхит бүтээгдэхүүн импортлох, ханган нийлүүлэх	3 жил
Нэмэлтээр тусгай зөвшөөрөл олгох			
1	Эс икс би ХХК	Оношлуур импортлох, ханган нийлүүлэх	3 жил





Эрүүл мэндийн сайдын  
2017 оны 09 сарын 07 өдрийн  
А/349 дугаар тушаалын 2 дугаар хавсралт

**ЭМ ХАНГАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ЭРХИЙГ ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН  
НЭР, ЧИГЛЭЛ, ХУГАЦАА**

№	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх хугацаа
1	Ди и жи эф ай эм ХХК	Шүдний материал, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох, ханган нийлүүлэх	3 сар